



ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/113

Улаанбаатар хот

Маргаан шийдвэрлэх комиссын тогтоолыг
баталгаажуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Оюуны өмчийн газрын дэргэдэх маргаан шийдвэрлэх комиссын ажиллах журмын 5.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Патент марк” оюуны өмчийн итгэмжлэгдсэн товчооноос ирүүлсэн мэдүүлгийн 10-2016-0005819 дугаартай “Бичил ширхэглэгт эм түгээх систем” нэртэй бүтээлд шинэ бүтээлийн патент олгохоос татгалзсан шийдвэрийг хүчингүй болгуулах тухай гомдлын шаардлагыг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн Оюуны өмчийн газрын дэргэдэх маргаан шийдвэрлэх комиссын 2020 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 06 дугаар тогтоолыг баталгаажуулсугай.

2. Маргаан шийдвэрлэх комиссын тогтоолыг баталгаажуулсантай холбогдуулж хэрэгжилтийг хангаж ажиллахыг маргаан шийдвэрлэх комисс /С.Ганзориг/-т даалгасугай.

ДАРГА

Ц.АЗБАЯР

000538